

**Төсвийн ерөнхийлөн захирагч буюу байгаль орчин, аялал жуулчлалын сайд аймаг,  
нийслэлийн засаг дарга нарын хооронд байгуулсан 2017 оны гэрээний биелэлтэд  
хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга**

2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр.

Улаанбаатар хот

**Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго:**

Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд аймаг, Нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 2017 оны хамтран ажиллах гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлэлт өгөх.

**Хамарсан хугацаа, гэрээний тоо хэмжээ**

2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатай аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан нийт 22 гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.

**Хяналт шинжилгээ, үнэлгээний дүн**

2017 оны хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолын дагуу дүгнэж, аймаг бүрээр гаргавал дараах байдалтай байна.

Аймаг, нийслэлийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Аймаг, нийслэл	Гэрээнд тусгасан нийт арга хэмжээ	Тасарсан арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/
1.	Дархан-Уул	58	1	88.4
2.	Увс	64	-	88.0
3.	Өмнөговь	56	-	86.5
4.	Дорнод	81	1	86.0
5.	Дорноговь	40	-	85.9
6.	Говьсүмбэр	33	1	85.3
7.	Өвөрхангай	67	1	83.9
8.	Төв	66	-	83.3
9.	Говь-Алтай	49	2	82.8
10.	Сүхбаатар	49	1	82.5
11.	Хэнтий	73	1	82.2
12.	Завхан	69	5	81.2
13.	Архангай	72	5	81.2
14.	Нийслэл	87	-	80.0
15.	Хөвсгөл	73	2	79.9
16.	Баян-Өлгий	60	3	79.8
17.	Орхон	65	2	79.6
18.	Ховд	64	1	78.3
19.	Булган	78	2	77.7
20.	Дундговь	41	1	77.0
21.	Баянхонгор	71	1	76.2
22.	Сэлэнгэ	72	2	76.1
Нийт				81.9

## **АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ АРГА ХЭМЖЭЭ**

**АРХАНГАЙ АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Ховор ашигт ургамлын нөөцийн судалгааны ажлын хэрэгжилт хангалтгүй. Нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, өвс хужир, мараа тавих, 2 арга хэмжээний биелэлт байхгүй. Тарваганы тооллого судалгаа хийгээгүй, 2018 онд хийхээр төлөвлөсөн байна.

**Тусгай хамгаалалтын чиглэлээр:** Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажил хийгдээгүй байна.

**Усны чиглэлээр:** Хөв цөөрөм байгуулах талаар Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Цац багт нутгийн иргэдийн оролцоотойгоор хөв байгуулах ажлыг зохион байгуулсан бөгөөд энэ жил хур бороо бага орсон тул ус бага тогтсон. 2018 оны байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд холбогдох зардлыг тусган усыг тогтмол байлгах арга хэмжээг авч ажиллахаар нутгийн иргэдтэй тохирсон байна.

**ӨМНӨГОВЬ АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу байгаль орчин, аялал жуулчлалын салбарын чиглэлээр гүйцэтгэх ажлууд, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд 3 арга хэмжээг давхардуулан төлөвлөсөн. Тарвагагүй аймаг тарваганы тооллого хийнэ гэж төлөвлөсөн байна.

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Биологийн төрөл зүйлийн судалгаа хийх арга хэмжээний биелэлт байхгүй, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос эвдэрч эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээний биелэлт хангалтгүй.

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ. Усны чиглэлээр:** Усны тоо бүртгэлийг сав газрын захиргаатай хамтран явуулж, усны мэдээллийн санд оруулах ажил хийгдээгүй.

**СЭЛЭНГЭ АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах ажлын хэрэгжилт хангалтгүй. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос эвдэрч эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй.

**Усны чиглэлээр:** Нуур, булаг шандыг хамгаалах, хашаалуулах ажлыг гүйцэтгэх ажил ямар булаг шандыг хамгаалж хашаалуулсан тухай байхгүй учир энэ төрлийн ажил хийгдээгүй гэж үзлээ. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас Ерөө, Хүдэр голуудад үүссэн хохирлыг нөхөн сэргээх, усны нөөцөд учирсан хохирлыг сав газрын захиргаатай хамтарч тооцох ажил ус бохирдуулсны төлбөртэй хамаарал байхгүй, усны нөөцөд учирсан хохирлыг тооцох журам аргачлал нь 2015 онд батлагдсан. Хамааралгүй зүйл бичсэн тул ийм төрлийн ажил хийгдээгүй гэж үзлээ. Гадаргын усны тоо бүртгэл болон ус бохирдуулагчийн тооллогыг захиргаатай хамтран явуулж, улсын усны мэдээллийн санд оруулах ажил ус бохирдуулагчийн тооллогыг хийгээгүй, 2017 онд гүйцэд зохион байгуулаагүй. Усны сан бүхий газрыг нөхөн сэргээх, хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, хил заагийг тогтоож, газар тариалан, уул уурхайн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын зүгээс хяналт тавих ажил хэдэн удаа ямар байгууллагуудтай хамтарсан шалгалт хийсэн тухай бичих, усны тухай хуулийн хэрэгжилт маш муу хангадаг.

**СҮХБААТАР АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах ажил хийгдээгүй байна.

**ДАРХАН-УУЛ АЙМАГ. Усны чиглэлээр:** Хараа голын цутгал Чулуут, Хар-Ус зэрэг голуудын горимын судалгааг хийж, тайлагнах ажил хийгдээгүй 2018 онд хийхээр төлөвлөсөн байна. Хаврын шар усны, зуны хур борооны үерийн илүүдэл усыг хуримтлуулах хөв цөөрмийг байгуулж, гадаргын усыг хуримтлуулах замаар малын ус

хангамжийг шийдвэрлэх, экосистемийн таатай нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх (хөв цөөрөм байгуулах) ажлын хэрэгжилт хангалтгүй.

**БАЯН ХОНГОР АЙМАГ. Усны чиглэлээр:** Баян-Овоо сумын Урд Үүдэд бороо цасны ус хуримтлуулах хөв байгуулах (зураг, төсөв 2013 онд хийгдсэн) ажлыг хэрэгжүүлэх ажил нь хөрөнгийн асуудал шийдэгдээгүйн улмаас хийгдээгүй байна. Баянхонгор аймгийн Шаргалжуутын рашааны ордын нөөцийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулах ажил бүрэн хэрэгжээгүй байна.

**ХӨВСГӨЛ АЙМАГ. Тусгай хамгаалалтын чиглэлээр:** Байгалийн нөөц болон дурсгалт газрын хамгаалалтын горим, дэглэмийг тогтоож хамгаалалтыг хэрэгжүүлэх ажил хийгдээгүй байна.

**Усны чиглэлээр:** Малын ус хангамжид ашиглагддаг нуур, булаг шандыг хашиж, хамгаалах ажлыг гүйцэтгэх ажил хийгдээгүй байна.

**ДОРНОД АЙМАГ. Усны чиглэлээр:** Хот, суурин газрын орчим болон хилийн дагуу усан хил бүхий газарт голын эрэгт эргийн хамгаалалтыг байгуулах ажлыг 2018 онд Хэрлэн голд эргийн хамгаалалтын ажил хийхээр төлөвлөгдсөн 208 сая төгрөг аймгийн ИТХ-аар батлуулсан байгаа гэсэн тайлан ирүүлсэн ажил хийгдээгүй байна. Сумдын төвийн хүн амын ундны усны эх үүсвэрт ус цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж шинээр суурилуулах /Цагаан-Овоо, Сэргэлэн, Чойбалсан, Булган, Дашбалбар, Гурванзагал, Чулуунхороот гэсэн 7 суманд хийх байсан. гэтэл 3 суманд хийсэн байна.

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Тарваганы тооллого судалгааны ажил удаашралтай байна.

**Тусгай хамгаалалтын чиглэлээр:** Монгол Улсын хилийн дагуух тусгай хамгаалалтын захиргаадтай хамтарч ажилладаг хөрш орны талуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд орон нутгийн удирдлагын зүгээс ТХГ-уудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажил хийгдээгүй. Бугат сумын Хөвчийн нуруу, Тонхил сумын Хойт гол, Хараат ширээтийн уулс, Алтай сумын Хойд гол, Баяновоо-Цагаанбулаг зэрэг нэр бүхий нийт 300081,76 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтэст бүртгэгдсэн байна. /ИТХ-ын шийдвэрийн дугаар байхгүй, Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан ИТХ-аар оруулах, батлуулах ажил хийгдээгүй. Тарваганы тооллого судалгааны ажил удаашралтай байна.

**Усны чиглэлээр:** Хаврын шар усны, зуны хур борооны үерийн илүүдэл усыг хуримтлуулах хөв цөөрмийг байгуулж, гадаргын усыг хуримтлуулах замаар малын ус хангамжийг шийдвэрлэх, экосистемийн таатай нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх (Хөв цөөрөм байгуулах) ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Гадаргын усны тоо бүртгэл болон ус бохирдуулагчийн тооллогыг сав газрын захиргаадтай хамтран явуулж, улсын усны мэдээллийн санд оруулах ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ. Тусгай хамгаалалтын чиглэлээр:** Улсын тусгай хамгаалалттай газарт хийх тэмдэгжүүлэлтийг бэлтгэн байрлуулаагүй байна.

**Усны чиглэлээр:** Хаврын шар усны, зуны хур борооны үерийн илүүдэл усыг хуримтлуулах хөв цөөрмийг байгуулж, гадаргын усыг хуримтлуулах замаар малын ус хангамжийг шийдвэрлэх ажил хийгдээгүй байна. Ногооннуур сумын Нарийн гол, Бөхмөрөн голын голдирлыг нөхөн сэргээх ажил хийгдээгүй байна.

**ЗАВХАН АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Тарваганы тооллого судалгаа хийгээгүй. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос эвдэрч эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд нөхөн сэргээлт хийгээгүй байна.

**Тусгай хамгаалалтын чиглэлээр:** 2017 онд 15 сумын 52 газрыг орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авч Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлийн системд бүртгүүлсэн. /ИТХ-ын тогтоолын болон албан бичгийн дугаар

байхгүй/, Байгалийн нөөц болон дурсгалт газрын хамгаалалтын горим, дэглэмийг тогтоож хамгаалалтыг хэрэгжүүлэх ажил хийгдээгүй байна, Тарваганы тооллого

судалгаа хийгээгүй, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос эвдэрч эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд нөхөн сэргээлт хийгээгүй байна.

**Усны чиглэлээр:** Отгонтэнгэр, Улаан хаалга, Зарт, Цэцүүх, Баянзүрийн рашааны ордуудын гидрогеологийн судалгааны ажил хийгдээгүй байна. Аймгийн төвийн үерийн хамгаалалтын далангийн бүрэн бүтэн байдал, өргөтгөлийн үйл ажиллагааг хянан үзэж, шаардлагатай өөрчлөлт хийх ажил хийгдээгүй байна. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, самбаржуулах, хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах хяналт хийж дутагдал илэрсэн газарт зөрчлийг арилгах ажлын хог хаягдлыг цэвэрлэх ажил хийгдээгүй байна.

**ХЭНТИЙ АЙМАГ. Усны чиглэлээр:** Хэрлэн голын нөөц горимыг тогтоох зорилгоор Дэлгэрхаан сумын Хөмөлтийн гүүр, Баян- Овоо сумын Хэрлэн голын гүүрний орчим гадаргын усны түвшин хэмжигч автомат багаж суурилуулах ажил хийгдээгүй. Усны чанарын хяналтын тогтолцоог бий болгож, сумдын төвийн хүн амын ундны усны эх үүсвэрт ус цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж шинээр суурилуулах ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Хөв цөөрөм байгуулах ажлыг гүйцэтгэх ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

**ХОВД АЙМАГ. Усны чиглэлээр:** 5 булаг шандыг хашиж хамгаалах ажил Дарви, Чандмань суманд 2 булгийг хашиж хамгаалсан байна хэрэгжилт хангалтгүй. Жаргалант сумын Наран, Рашаант багууд, Цэцэг, Дөргөн, Чандмань, Мөст, Алтай сумдын ундны усны худагт зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж тавих ажил хийгдээгүй. Цэцэг, Дөргөн, Чандмань, Мөст, Алтай сумдын ундны усны худагт зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж тавих ажил хийгдээгүй. Дөргөн сумын төвийн унд ахуйн усны эх үүсвэрийн эрэл хайгуул судалгааны ажлыг гүйцэтгүүлэх талаарх ажлын үндэслэлийг боловсруулж, зохион байгуулж, тайлагнах ажил хийгдээгүй.

**ДУНДГОВЬ АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос эвдэрч эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

**Усны чиглэлээр:** Хаврын шар усны, зуны хур борооны үерийн илүүдэл усыг хуримтлуулах хөв цөөрмийг байгуулж, гадаргын усыг хуримтлуулах замаар малын ус хангамжийг шийдвэрлэх, экосистемийн таатай нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажил хийгдээгүй. Гадаргын усны тоо бүртгэл болон ус бохирдуулагчийн тоо тооллогыг сав газрын захиргаатай хамтран явуулж, улсын усны мэдээллийн санд оруулах ажлын хэрэгжилт хангалтгүй. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, самбаржуулах хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

**БУЛГАН АЙМАГ. Хүрээлэн буй орчны чиглэлээр:** Нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах ажлын биелэлт хангалтгүй. Тарваганы тооллого хийгээгүй байна.

**Усны чиглэлээр:** Могод суманд орших Загаст нуурын эхийг хашиж хамгаалах, голдирлыг сэргээх ажил хийгдээгүй байна.

**ОРХОН АЙМАГ. Усны чиглэлээр:** Орхон аймгийн төвийн ихэнх өрх хашаандаа гар худагтай, муу усны цооног, жорлонтой байгаа асуудлыг анхаарах, нэмж худаг гаргах зөвшөөрлийг хязгаарлах хамаарах тайлан байхгүй ажил хийгдээгүй. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх, хог хаягдлыг цэвэрлэх, онцгой /50 метр/ болон энгийн /200 метр/ хамгаалалтын бүсэд анхааруулах самбар байрлуулах хамаарах тайлан байхгүй ажил хийгдээгүй. Хангал голын усны чанарыг анхаарч,

бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх хамаарах тайлан байхгүй ажил хийгдээгүй.

**ТӨВ АЙМАГ. Усны чиглэлээр:** Усны тооллого зохион байгуулах ажлыг 27 суманд хийхээс 13 суманд хийсэн байна. Гадаргын усны тоо бүртгэл болон ус бохирдуулагчийн тооллогыг сав газрын захиргаадтай хамтран явуулж, улсын усны мэдээллийн санд оруулах ажил бүрэн хийгдээгүй. Хөв цөөрөм байгуулах ажил бүрэн хийгдээгүй байна.

#### **ДҮГНЭЛТ:**

1. Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний биелэлт дунджаар **81.9** хувь буюу “В” үнэлгээтэй хэрэгжсэн байна.
2. Баянхонгор, Баян-Өлгий, Увс, Дорнод, Орхон, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгууд гэрээний хоёрдугаар хавсралт буюу Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу байгаль орчин, аялал жуулчлалын салбарын чиглэлээр гүйцэтгэх ажлуудаа хугацаанд нь гаргаж ирүүлээгүйгээс гэрээ дүгнэхэд хүндрэлтэй байв.
3. Увс аймаг гэрээний нэгдүгээр хавсралтын биелэлтийг бичмэл тайлан хэлбэрээр гаргасан тул гэрээнд заасан арга хэмжээний дагуу биелэлтийг ойлгомжтой тодорхой гаргах, гэрээнд тусгагдсан ажлуудыг орхигдуулахгүй тайлагнахад анхаарах шаардлагатай байна.
4. Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Баян-Өлгий, Завхан, Сүхбаатар аймгууд усны талаар баримтлах бодлого, хэрэгжүүлж буй ажлуудад орон нутгийн төсвөөс шийдээгүй, анхаарал муу хандуулсан байна.
5. Зарим аймгууд төлөвлөсөн ажилаа хийгээгүй, өөр ажилаар орлуулан буруу тайлагнах, төсөв төлөвлөөгүй зэрэг зөрчил гарч байна.
6. Тайланг хүлээн авахдаа шалгаж нягталдаггүй, дутуу байсан нь аймгийн тайланг дахин танилцаж дүгнэхэд хүндрэлтэй байгааг Төрийн захиргааны удирдлагын газар цаашид анхаарах шаардлагатай байна.

#### **САНАЛ, ЗӨВЛӨМЖ:**

1. Гэрээнд заасан арга хэмжээний дагуу биелэлтийг ойлгомжтой, тодорхой тайлагнах, гэрээнд тусгагдсан ажлуудыг орхигдуулахгүй байхыг онцгойлон анхаарч тайлагнаж суралцах;
2. Баянхонгор, Баян-Өлгий, Увс, Дорнод, Орхон, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ аймгууд төлөвлөлт, тайлагналт, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд онцгойлон анхаарах,
3. Тухайн орон нутагт хийгдсэн хяналт-шалгалтын ажлын үр дүнг тодорхой бичиж ирүүлэх,
4. Биелэлт хангалтгүй, хэрэгжилт тасарсан ажлуудыг анхаарч, хэрэгжилтийг эрчимжүүлэх, дараа жилийн төлөвлөлтөд оруулах;
5. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүх аймгууд хэрэгжүүлж ажиллах;
6. 2018 оны гэрээг байгуулахдаа дээрх санал, зөвлөмжүүдийг тусган хэрэгжүүлэх, гэрээний хавсралтыг ТЗУГ-аас анхаарч төлөвлөх

**Танилцсан:**

Төрийн нарийн бичгийн дарга

Ц.Цэнгэл.....

**Ажлын хэсгийн ахлагч:**Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын газрын даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

В.Жавзан.....

**Гишүүд:**Аялал жуулчлалын бодлого  
зохицуулалтын газрын мэргэжилтэн

Т.Пүрэвсүрэн .....

Тусгай хамгаалалттай нутгийн  
удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

Г.Энхмөнх .....

Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн  
удирдлагын газрын мэргэжилтэн

П.Шинэцэцэг.....

Төрийн захиргааны удирдлагын  
газрын мэргэжилтэн

М.Соёлмаа.....

Цэвэр технологи, хөрөнгө оруулалт,  
үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

Ч.Ганбат.....

Ойн бодлого зохицуулалтын  
газрын мэргэжилтний түр орлон гүйцэтгэгч

Ц.Бямбасүрэн.....

Усны нөөцийн хэлтсийн мэргэжилтэн

Х.Сэвжидмаа.....

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

О.Батсайхан.....

**Тайлан нэгтгэсэн:**Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын мэргэжилтэн

Б.Мөнхбат .....







